



**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу 44, Засгийн газрын III байр,
Утас: 26-22-27, И-мэйл: letter@mecs.gov.mn
Вэб сайт: meds.gov.mn

2023.09.01 № 9/4091

танай _____-ны № _____-г

Г Хөтөлбөрийн бүртгэл эхлүүлэх тухай Г

Япон Улсын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газартай хамтран “Хүний нөөцийг хөгжүүлэх JDS тэтгэлэгт хөтөлбөр”-ийг 2001 оноос хойш өнөөг хүртэл амжилттай хэрэгжүүлж байна. Тус хөтөлбөрийн хүрээнд нийт 405 төрийн албан хаагчийг (2023 оны хичээлийн жилд хамрагдаж буй оюутны тоо багтсан) Японы их, дээд сургуулиудын магистрийн хөтөлбөрт, 11 иргэнийг докторын хөтөлбөрт суралцуулахаар илгээсэн. Одоогийн байдлаар суралцахаар явсан нийт албан хаагчдын 363 нь сургуулиа амжилттай төгсөж, эх орондоо буцаж ирж, сурсан чиглэлээрээ үр бүтээлтэй ажиллаж байна.


2020 оны 02 дугаар сарын 07-ны өдөр Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газрын төлөөллөөс бүрдсэн хамтын ажиллагааны урьдчилсан судалгааны баг хэлэлцээр байгуулан, 2020-2023 онд хүлээн авах хөтөлбөрийн чиглэл, хамрагдах хүрээ (хавсралт 1)-г шинээр тодорхойлсон. 2023 оны 8 дугаар сарын 29-ний өдөр Удирдах Зөвлөлөөс 2023 оны хөтөлбөрийн сонгон шалгаруулалтад баримтлах ерөнхий зарчмыг баталлаа.

Иймд Япон улсад суралцах хүсэлтэй харьяа яамны болон салбар (харьяа агентлагууд)-ын төрийн жинхэнэ албан хаагчдад хөтөлбөрийн талаарх мэдээллийг өргөнөөр хүргэж, сонгон шалгаруулалтад оролцуулна уу.

Тэтгэлэгт хөтөлбөрийн бүртгэл 2023 оны 9 дүгээр сарын 4-ний өдрөөс эхэлж, магистрын бүртгэл 11 дугаар сарын 6-ны өдөр, докторын бүртгэл 12 дугаар сарын 8-ний өдөр хаагдах болно. Хөтөлбөрийн өргөдөл гаргагчдад тавигдах шаардлагыг Хавсралт 2-оос үзнэ үү.

Бусад дэлгэрэнгүй мэдээллийг JICE JDS Монгол дахь Төслийн Оффис (95495902, 99785902, Email: jds.mongolia@jice.org)-оос лавлана уу.

Хавсралт: 3.. хуудастай



14239 4112

Хүний Нөөцийг Хөгжүүлэх JDS Тэтгэлэгт Хөтөлбөрийн дөрвөн багц жилийн ерөнхий зураглал

Дэд Хөтөлбөр (JDS зорилтот тэргүүлэх чиглэл)	Бүрэлдэхүүн хэсэг (JDS зорилтот хөгжлийн асуудал)	Дэд бүрэлдэхүүн хэсэг	Хүлээн авах Их сургууль Хүлээн авах тэнхим	Курс /Хөтөлбөр	Эзэмших зэрэг	Хүлээн авах хүний тоо	Боломжит судалгааны сэдвүүд / Суралцах чиглэл	Зорилтот элсэгч
1. Макро эдийн засгийн эрүүл үйл ажиллагаа ба засаглалыг бэхжүүлэх	1-1 Төрийн санхүүгийн удирдлагын чадавхийг сайжруулах	1-1-1 Төрийн санхүүгийн удирдлага	Сайтамагийн Их Сургууль Хүмүүнлэг, нийгмийн ухаан судлалын тэнхим	Эдийн засгийн магистрын хөтөлбөр (MEcon хөтөлбөр)	Эдийн засгийн ухааны магистр	2	Тогтвортой хөгжлийн бодлого Хөгжлийн эдийн засаг Макро эдийн засгийн төлөвлөлт Төрийн санхүүгийн менежмент Төрийн хөрөнгө оруулалтын бодлого Дотоод аудит Олон улсын татварын зохицуулалт Төрийн өрийн менежмент Хөрөнгийн татвар	Бүх төрийн жинхэнэ албан хаагч болон Монгол банк болон Монгол улсын хөгжлийн банкны албан хаагчид
		1-1-2 Төрийн захиргаа	Мэйжи Их Сургууль Засаглал судлалын тэнхим	Мэргэжлийн чиглэл: (1) Төрийн бодлого (2) Олон улсын хөгжлийн бодлого (3) Нийтийн оролцоонд түшиглэсэн	Олон нийтийн бодлого боловсруулалтын магистр	2	Нийгмийн халамжийн удирдлага Нийгмийн аюулгүй байдлын удирдлага Эрүүл мэндийн бодлого Хөдөөгийн хөгжил Бүсчилсэн хөгжил Хүн амын бодлого/ Хотын төвлөрлийг сааруулах бодлого Татварын удирдлага Олон улсын боловсролын харьцуулсан судалгаа E-засаглал Төрийн худалдан авах ажиллагааны бодлого	
	1-2 Эрчимтэй зах зээлийн эдийн засгийг бүрдүүлэхэд чиглэсэн дэмжлэг	1-2-1 Санхүүгийн бодлого, хөрөнгийн зах зээлийн бодлого	Олон Улсын Их Сургууль Олон улсын харилцааны тэнхим	Олон улсын хөгжлийн хөтөлбөр (IDP), (зэвэл Япон-глобал хөгжлийн хөтөлбөр (JGDP) (Гол судалгаа: Хөгжлийн бодлого, эдийн засгийн бодлого))	а. Олон улсын хөгжил b. Эдийн засгийн ухааны магистр	2	Санхүүгийн бодлого Хөрөнгийн зах зээлийн бодлого Үнэт цаас, бондын зах зээлийг сэргээх Гадаадын шуд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бодлого Дижитал зах зээлийн бодлого болон менежмент	
		1-2-2 Бизнес, эдийн засгийн эрх зүйн тогтолцоо	Кюүшүгийн Их Сургууль Хуулийн тэнхим	Олон улсын эдийн засаг, бизнесийн хууль (IEBL) Хуульзүйн магистрын хөтөлбөр	Хуульзүйн магистр	1	Бизнес, эдийн засгийн эрх зүйн тогтолцоо Олон улсын корпорацитай гэрээ байгуулах тухай хууль эрхзүйн хэлэлцээр Эвлэрүүлэн зуучлал ба бусад маргааныг хянан шийдвэрлэх менежмент Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль Өрсөлдөөний тухай хууль Олон улсын санхүүгийн хууль, журам	
2. Хүрээлэн буй орчинтой зохицсон эдийн засгийн тэнцвэртэй өсөлтийг хангах	2-1 Аж үйлдвэрийн бодлого ба бизнесийн удирдлага	Олон Улсын Их Сургууль Олон улсын менежментийн тэнхим	Бизнесийн удирдлага/Япон-Глобал хөгжлийн хөтөлбөр (JGDP)	Бизнесийн удирдлагын магистр	2	Аж үйлдвэрийн бодлого Хөдөө аж ахуйн бодлого Бизнесийн удирдлага болон санхүү ЖДҮ-ийн хөгжил Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих Тогтвортой хөгжлийн зорилтуудын хяналт		
		Хирошимагийн Их Сургууль Хүмүүнлэг, нийгмийн ухаан судлалын тэнхим	Хүмүүнлэг, нийгмийн ухааны салбар Олон улсын эдийн засаг, хөгжлийн хөтөлбөр "Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн талаарх тусгай боловсролын хөтөлбөр"	а. Эдийн засгийн ухааны магистр b. Бизнесийн удирдлагын магистр c. Олон улсын хамтын ажиллагаа судлалын магистр d. Философийн	2			
		Ухаалаг нийгэм практик шинжлэх ухааны тэнхим		Философийн ухааны магистр				
2-2 Өсөлтийг хангахуйц өндөр чанартай дэд бүтцийг байгуулах	2-3 Хотын хүрээлэн буй орчны менежментийг сайжруулах	Нагаока технологийн их сургууль Иргэний барилга, байгаль орчны инженерчлэлийн тэнхим	Барилга, хүрээлэн буй орчны инженерчлэлийн тэнхим, Хүний нөөцийг хөгжүүлэх олон улсын хөтөлбөр	Инженерийн магистр	2	Хотын бодлого Хот / бус нутгийн төлөвлөлт Тээврийн төлөвлөлт Төр, хувийн хэвшлийн түншлэл Хотын хөгжлийн төслийн менежмент Геодезийн мэдээллийн дүн шинжилгээ Бохиор ус цэвэрлэх төлөвлөгөө, менежмент Логистикийн менежментийн систем Нэгдсэн тээвэр		
		Цүкүбагийн Их Сургууль Шинжлэх ухаан, технологи судлалын тэнхим	Хүрээлэн буй орчин судлалын магистрын хөтөлбөр/SUSTEP Хөтөлбөр	Хүрээлэн буй орчин судлалын магистр	2	Хотын байгаль орчны бодлого Хүрээлэн буй орчны үнэлгээ Байгаль орчны инженерчлэл Гамшгийн менежмент Олон улсын байгаль орчны тухай хууль		
Жилд хүлээн авах нийт хүний тоо						15		

Магистрын хөтөлбөрийн элсэгчдэд тавигдах шаардлага

Иргэншил	Монгол улсын иргэн байх
Нас	2024 оны 4-р сарын 1-ний байдлаар 25-39 настай байх (1984 оны 4-р сарын 2-оос 1999 оны 4-р сарын 1-ний хооронд төрсөн байх)
Боловсролын байдал	<ul style="list-style-type: none"> Монголын болон гадаадын магадлан итгэмжлэгдсэн их дээд сургуульд бакалаврын зэрэг эзэмшсэн байх. Бүрэлдэхүүн хэсэг 1-2-2 Кюүшүгийн Их Сургуулийн Хуулийн тэнхимд өргөдөл гаргагч нь хуулийн чиглэлээр бакалаврын зэрэг хамгаалсан байх.
Ажил байдал	<ul style="list-style-type: none"> Дараах хүмүүс хөтөлбөрт хамрагдах боломжтой: <ol style="list-style-type: none"> Төв, орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудад ажиллаж буй төрийн жинхэнэ албан хаагч (Төрийн тусгай болон захиргааны албан хаагч) Монгол банк болон Монголын хөгжлийн банкны ажилтан
Ажлын туршлага	<ul style="list-style-type: none"> Өргөдлийн маягт хүлээн авах эцсийн өдрийн байдлаар 2-оос дээш жил дээрх албыг хашсан байх.
Хэлний мэдлэг	<ul style="list-style-type: none"> Магистрын түвшинд судалгаа хийхэд шаардагдах хэмжээний англи хэлний чадвартай байх. TOEFL iBT 60 (ITP 500), IELTS 5.5 дээш оноотой байвал давуу талтай. (Заавал шаардлагатай биш) Япон хэлний мэдлэгтэй бол давуу талтай. (Заавал шаардлагатай биш)
Эрүүл мэндийн байдал	Бие махбод, сэтгэцийн хувьд эрүүл байх. *JDS хөтөлбөрийн зүгээс зохион байгуулах эрүүл мэндийн үзлэгт хамрагдаагүй тохиолдолд сонгон шалгаруулалтаас хасна.
Хамрагдах боломжгүй хүмүүс	Дараах хүмүүс хөтөлбөрт хамрагдах боломжгүй. Үүнд: <ul style="list-style-type: none"> Одоогийн байдлаар ямарваа нэг тэтгэлэгт хамрагдаж буй эсвэл цаашид өөр тэтгэлэгт хамрагдах нь тодорхой болсон хүн. Гадаад орны тэтгэлгээр магистр болон түүнээс дээш зэрэг горилсон хүн. Хугацаат цэргийн албанд бүртгэгдсэн хүн, цэргийн дүйцүүлэх алба хааж байгаа хүн эсвэл түр хугацаагаар чөлөөлөгдсөн хүн.
Бусад	<ul style="list-style-type: none"> Сүүлийн сонгон шалгаруулалтад оролцохдоо байгууллагын удирдлагаасаа “Монгол улсдаа төгсөөд ирэхэд өмнөх албан тушаалд дээр нь эргүүлэн ажиллуулах тухай” баталгааны бичгийг авч ирүүлнэ. Тус тэтгэлгээр суралцахаар болсон тэнцэгчид нь "Амлалтын бичиг", "Баталгаажуулах бичиг"-ийг бөглөн, ирүүлэх шаардлагатай. JDS оюутнууд нь хөтөлбөрийн зорилгыг сайтар ухамсарлан, суралцаж төгсөөд буцаж ирэн, эх орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулах чин хүсэл эрмэлзэлтэй байх. JDS төгсөгчид нь Монгол Улсыг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулахын тулд төгсөж ирээд, 2.5 жилээс доошгүй хугацаанд амлалтын бичиг дэх үүргээ биелүүлж, өмнө нь ажиллаж байсан байгууллагадаа ажиллана” гэж БШУЯ-нд амлалтын бичиг гаргана.

Докторын хөтөлбөрийн элсэгчдэд тавигдах шаардлага

Зүйл	Тайлбар
Иргэншил	Монгол улсын иргэн байх
Нас	2024 оны 4-р сарын 1-ний байдлаар 45 болон түүнээс доош настай байх (1978 оны 4-р сарын 2-ны өдрөөс хойш төрсөн байх)
Боловсрол	<p>JDS хөтөлбөрийн магистр төгсөгч эсвэл Япон улсад магистр төгссөн байх Зарчмын хувьд магистрын зэрэг горилсон сургуульдаа элсэх.</p> <p>Нэгээс дээш хэвлэгдсэн эрдэм шинжилгээний өгүүлэл/нийтлэлтэй байх. Үүнд, дараах элсэгчид мөн хамрагдана.</p> <ol style="list-style-type: none"> 1) Эрдэм шинжилгээний ажил нь хүлээн зөвшөөрөгдсөн боловч хараахан хэвлэн нийтлэгдээгүй байгаа өргөдөл гаргагч 2) Эрдэм шинжилгээний ажлаа хураалган, хянуулж буй өргөдөл гаргагч 3) Удирдах багштайгаа хамтран эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл/нийтлэл нийтлүүлэх тодорхой төлөвлөгөөтэй өргөдөл гаргагч
Ажил байдал	<p>Дараах хүмүүс хөтөлбөрт хамрагдах боломжтой:</p> <ol style="list-style-type: none"> 1) Төв, орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудад ажиллаж буй төрийн жинхэнэ албан хаагч (Төрийн тусгай болон захиргааны албан хаагч) 2) Монгол банк болон Монголын хөгжлийн банкны ажилтан
Ажлын туршлага	Японд магистр төгссөнөөс хойш 2-оос дээш жил дээр дурдсан албыг хашсан байх
Эрүүл мэндийн байдал	<p>Бие махбод, сэтгэцийн хувьд эрүүл байх.</p> <p>*JDS хөтөлбөрийн зүгээс зохион байгуулах эрүүл мэндийн үзлэгт хамрагдаагүй тохиолдолд сонгон шалгаруулалтаас хасна.</p>
Хамрагдах боломжгүй хүмүүс	<p>Дараах хүмүүс хөтөлбөрт хамрагдах боломжгүй. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Одоогийн байдлаар ямарваа нэг тэтгэлэгт хамрагдаж буй эсвэл цаашид өөр тэтгэлэгт хамрагдах нь тодорхой болсон хүн. • Гадаад орны тэтгэлгээр докторын зэрэг горилсон хүн. • Хугацаат цэргийн албанд бүртгэгдсэн хүн, цэргийн дүйцүүлэх алба хааж байгаа хүн эсвэл түр хугацаагаар чөлөөлөгдсөн хүн.
Бусад	<ul style="list-style-type: none"> • Харьяа байгууллагын удирдах албан тушаалтнаас дараах бичиг баримтыг авч ирүүлэх шаардлагатай. (Нэр дэвшүүлэх тодорхойлолт, өргөдөл гаргагчийн тодорхойлолт. Өргөдөл гаргагчийн тодорхойлолтод ажил байдлын үнэлгээ болон судалгааны ажлын сэдэв нь элсэгчийн цаашдын ололт амжилт, байгууллагынхаа хөгжилд хэрхэн нөлөөлж чадах вэ гэдгийг дурдах) • Элсэх хүсэлтэй сургуулийн удирдагч багшаас тодорхойлолт бичүүлж авах шаардлагатай. (Удирдагч багш судалгааны ажлын төлөвлөгөөг хянасан байх) • Дэд хөтөлбөр, бүрэлдэхүүн хэсгүүдийн хүрээнд дурдсан Монгол Улсын хөгжлийн асуудалтай холбоотой судалгааны ажил бичих шаардлагатай. • Зарчмын хувьд 3 жилийн хугацаанд докторын зэргээ хамгаалах ёстой. Баталгаатай төгсөж чадна гэдэг нь нотлогдсон тохиолдолд суралцах хугацааг хагас жилээр сунгах боломжтой.. • Тус тэтгэлгээр суралцах тэнцэгчид нь "Амлалтын бичиг", "Баталгаажуулах бичиг"-ийг бөглөн, ирүүлэх шаардлагатай. • JDS төгсөгчид нь Монгол Улсыг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулахын тулд төгсөж ирээд, 2.5 жилээс доошгүй хугацаанд амлалтын бичиг дэх үүргээ биелүүлж, өмнө нь ажиллаж байсан байгууллагадаа ажиллана” гэж БШУЯ-нд амлалтын бичиг гаргана. • Япон хэлний мэдлэгтэй бол давуу талтай. (Заавал шаардлагатай биш)